

**ДАРЛАТД САВНУУДАД ХИЙН СОРИЛТ, ТЕХНИКИЙН МАГАДЛАГАА ХИЙХ АЖИЛ
ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

Дугаар № *102* / *2022*

2022 оны *09* -р сарын *15* өдөр

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Амгалан дулааны станц ТӨХК-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Ш.Баянмөнх /цаашид захиалагч гэх/ нөгөө талаас Армос ХХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Гансэрээ /цаашид гүйцэтгэгч гэх /хамтад нь/ цаашид талууд гэх / нар нь Монгол улсын иргэний хуулийн 343-358 дугаар зүйл, 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах зүйлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Гэрээний зорилго

1.1 Гэрээний зорилго нь “Даралтад савнуудад хийн сорилт, техникийн магадлагаа хийх” ажлыг дор дурдсан хугацаанд техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгэж захиалагч талд хэвийн үйл ажиллагааг хангаж хүлээлгэн өгөх, Захиалагч нь гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийг дүгнэж зохих шаардлагыг хангасан гэж үзвэл энэхүү гэрээгээр тохиролцсон хугацаанд ажлын хөлсийг төлөх, харилцан үүрэг хүлээх, хариуцлагыг тогтоох, ажил эхлэх, гүйцэтгэх, дуусах явцтай холбоотой үүссэн харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Гэрээний нөхцөл, ерөнхий зүйл

2.1 “Даралтад савнуудад хийн сорилт, техникийн магадлагаа хийх” ажлыг 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн 09 дүгээр сарын 30-нд 12 хоногт багтаан гүйцэтгэж дуусгана.

Гурав. Төлбөр тооцоо

3.1 Гэрээт ажлын үнэ нь **10,648,000** /арван сая зургаан зуун дөчин найман мянга/ төгрөг байхаар талууд харилцан тохиролцов. Энэ нь НӨАТ багтсан мөн Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28.6-р зүйлд зааснаар татвар даатгалтай холбоотой бүх зардлууд багтсан болно.

3.2 Гэрээт ажлын төлбөрийг гүйцэтгэсэн ажлын дүгнэлт, гэрээ дүгнэсэн актыг үндэслэн нэхэмжлэлийн дагуу гүйцэтгэгчийн Хаан банкны **5020563644** тоот дансанд 30 хоногийн дотор шилжүүлнэ.

Дөрөв. Гүйцэтгэгчийн эрх үүрэг

4.1 Гэрээт ажлыг шаардлагад заагдсан үзүүлэлтийн дагуу, гэрээний үнэд багтаан батлагдсан хугацаандаа чанартай хийж гүйцэтгэнэ.

4.2 Гэрээт ажлыг гүйцэтгэхдээ ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг бүрэн хангуулах, галын аюулаас урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг авч ажиллах ба эдгээр шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагч байгууллагын шаардлагаар ажлыг зогсооно.

4.3 Ажил гүйцэтгэх хугацаанд Эрчим хүчний системд мөрдөж буй ТАД, ААД болон холбогдох бусад дүрэм журмын мөрдөж ажиллана. Захиалагчийн тавьсан шаардлага зөвлөмжийг заавал биелүүлнэ.

Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэсний дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:

Тухайн тоноглолтой холбоотой бусад акт баримтууд 4хувь

4.4 Ажил гүйцэтгэхэд шаардлагатай багаж тоног төхөөрөмжүүдийг бүрэн хариуцна.

- 4.5 Гүйцэтгэгч тал захиалагчийн зөвшөөрөлгүйгээр гэрээний эрх үүрэг, хариуцлагыг бусдад шилжүүлэхгүй байх үүрэгтэй
- 4.6 Ажил гүйцэтгэгч компани нь уг ажлыг гүйцэтгэх явцдаа хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрмийг чанд мөрдөнө.
- 4.7 Ажил үйлчилгээг нэгэнт эхэлснээс хойш гэрээг цуцлах санал тавихгүй.
- 4.8 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүй нөхцөлд компани болон түүний ажилтан, гуравдагч этгээдэд учирсан хохирол, зардлыг бүрэн барагдуулах.
- 4.9 Ажлыг хугацаанд нь зохион байгуулж стандартын дагуу хийж гүйцэтгэн дүгнэлт гаргаж баталгаажуулна.

Тав: Захиалагчийн эрх үүрэг

- 5.1 Дүрэм, журам, стандартыг зөрчсөн чанарын гологдол, засвар үйлчилгээний явцад нэмэлт эвдрэл, гэмтэл гаргасан тохиолдолд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээг авах эрхтэй.
- 5.2 Баталгаат хугацаанд гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэсэн ажилтай холбоотой гэмтэл, доголдол гарвал дахин үнэ төлбөргүй хийж гүйцэтгэхийг шаардах эрхтэй.
- 5.3 Ажил гүйцэтгэх явцад гүйцэтгэгчийн ажилд захиалагч талаас хяналтыг тогтмол тавих, мэргэжлийн түвшинд чанартай, доголдолгүй, ажлын явц, үр дүнтэй танилцах, хугацаанд нь явуулахыг шаардах эрхтэй.
- 5.4 Захиалагч байгууллага нь гүйцэтгэгчтэй тохиролцсоны үндсэн дээр төсөвт багтаан нэмэлт ажил гүйцэтгүүлж болно.
- 5.5 Гүйцэтгэгч тал гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор гүйцэтгээгүй бол гэрээг цуцлах саналыг хүргүүлэх.
- 5.6 Гүйцэтгэгч талын үзүүлсэн үйлчилгээний доголдлын улмаас компанид болон гуравдагч этгээдэд хохирол учирсан тохиолдолд түүнийг арилгах, учирсан хохирлыг барагдуулахыг шаардах.
- 5.7 Үйлчилгээ үзүүлж байгаа мэргэжилтний зөвлөгөөг хөдөлмөрийн болон техникийн аюулгүй ажиллагаандаа баримтлах.
- 5.8 Ашиглаж байгаа техник хэрэгслийн талаар Гүйцэтгэгчээс шаардсан ажлын жагсаалт, материалыг гаргаж өгөх.

Зургаа: Талуудын хүлээх үүрэг хариуцлага

- 6.1 Гүйцэтгэгчийн буруугаас засварын ажлын хугацаа хэтэрвэл гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,1 %-иар хоног тутам гүйцэтгэгч алданги хүлээх ба уг алданги нийт үнийн дүнгийн 10 % иас хэтрэхгүй байна.
- 6.2 Захиалагчийн буруугаас төлбөр төлөх хугацаа хэтэрвэл гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,1% -ийн алданги хүлээх ба нийт үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.
- 6.3 Компаний дотоод журам зөрчих, ажлын байрандаа ёс бус үйл ажиллагаа явуулах согтууруулах ундаа уусан тохиолдолд ажил гүйцэтгэх гэрээг цуцлах ба гүйцэтгэсэн ажлын хөлсийг төлөхөөс татгалзана.
- 6.4 Захиалагчийн саналаар нэмэлт ажил хийгдэх, төсөвт ажилбар, шинээр тоног төхөрөмж солих, засварлах, механизмын зардал дутуу тусгагдсан, үнийн зөрүү гарсан тухай бүр хоёр тал харилцан тохиролцож акт протоколоор баталгаажуулж шийдвэрлэнэ.
- 6.5 Захиалагчийг төлөөлж гэрээний хугацаанд ажлын гүйцэтгэлтэй холбоотой асуудлыг Амгалан дулааны станц ТӨХК-ийн Зуухан цехийн дарга Э. Ариунболд хариуцан ажиллана. Утас-99727172.
- 6.6 Нийлүүлэгчийг төлөөлж гэрээтэй холбоотой асуудлыг АРМОС ХХК-ийн менежер Д.Мөнхтулга хариуцан ажиллана. Утас-88107890.

Долоо: Давагдашгүй хүчин зүйл

7.1 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал гэдэгт үерт автах гал түймэрт нэрвэгдэх, дэлбэрэлтэд өртөх газар хөдлөх, зуд болох, тахал болон байгалийн бусад хүчин зүйлс мөн цэрэг дайны үйл ажиллагаа төрийн эрх барих байгууллагын шийдвэр буюу экспорт импортын хориг ажил хаялт үйлдвэрлэгчийн бүх төрлийн сул зогсолт зэрэг энэ гэрээг зохих ёсоор биелүүлэх боломжгүй байдлыг бий болгохыг ойлгоно.

7.2 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээ биелэгдэх боломжгүй болсон бол талууд бие биедээ нэн даруй мэдэгдэх ба гэрээт хугацаан дээрх нөхцөл байдал арилгах хүртэл хугацаагаар сунгагдах буюу нэг талын санаачлагчаар цуцлана.

7.3 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлыг зохиомлоор буюу болгоомжгүйгээр бий болгосноос бусад тохиолдолд учирсан хохирлыг хариуцах үүргээс талууд чөлөөлөгдөнө.

Найм: Гэрээг цуцлах, нэмэлт өөрчлөлт оруулах

8.1 Энэхүү гэрээнд заасан үүргээ талууд ноцтой зөрчсөн буюу хуульд заасан үндэслэл бий болсон бол талууд хэдийд ч гэрээг цуцлах эрхтэй.

8.2 Хэрвээ талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарвал хоёр тал урьдчилан тохиролцон хавсралтаар оруулж гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулснаар гэрээний нэгэн адил хууль зүйн хүчинтэй.

8.3 Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гүйцэтгэх ажлыг хугацаа хожимдуулсан, цаашид уг ажлыг үргэлжлүүлэх боломжгүй болсон тохиолдолд захиалагчийн санаачлагаар гэрээг цуцлана.

Ес: Бусад зүйл

9.1 Энэхүү гэрээний үйлчлэл нь талууд гэрээнд гарын үсэг зурж тамга дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болж, талууд тус тусын үүргээ биелүүлж баталгаат хугацаа дууссанаар дуусгавар болно.

9.2 Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.


9.3 Гэрээг монгол хэл дээр 4 хувь үйлдэж Захиалагч 3 хувийг Нийлүүлэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.

9.4 Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийднэ.

БАТЛАВ

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:


“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ш.БАЯНМӨНХ
Гарын үсэг: 

“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР
Э.МӨНХЖАРГАЛ
Гарын үсэг: 



БАТЛАВ

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“АРМОС” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ
Д.ГАНСЭРЭЭ
Гарын үсэг: 



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
БӨГӨӨД ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ
Ө.УДВАЛ -2

Гарын үсэг: *Э. Тогтмун*

ХАНГАМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Г.ЭРДЭНЭБИЛЭГ

Гарын үсэг: *Г.Эрдэнэбилэг*

ЗУУХАН ЦЕХИЙН ДАРГА
Э.АРИУНБОЛД

Гарын үсэг: *Э.Ариунболд*

ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА
П.ЗОРИГОО

Гарын үсэг: *П.Зоригоо*

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН
Г.САРУУЛ

Гарын үсэг: *Г.Саруул*

ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН:

ХАНГАМЖИЙН МЭРГЭЖИЛТЭН
Ш.АМИНЖАРГАЛ

Гарын үсэг: *Ш.Аминжаргал*

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх
дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1
Утасны дугаар: 77111251
РД: 6021646

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар
дүүрэг, 9-р хороо, Ногоон нуур гудамж, ЭсПиЭс
төв, 605 тоот
Утасны дугаар: 70157000, 88107890
РД: 5247764



ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР *Батжав* Э.МӨНХЖАРГАЛ

ДАРЛТАД САВНУУДЫН ХИЙН СОРИЛТ ХИЙЖ, ТЕХНИКИЙН МАГАДЛАГАА
ХИЙЛГЭХ АЖЛЫН ЭЗЭЛХҮҮН

№	Нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Хамгаалах клапан /диаметр/	Даралт /ата/
НЭГ. Хий хураагуур					
1	Шохойн чулуу №1 хий хураагуур /10м3/	ш	1	DN65	8
2	Шохойн чулуу №2 хий хураагуур /10м3/	ш	1	DN65	8
3	Уутат шүүлтүүр №1 хий хураагуур /5м3/	ш	1	DN50	8
4	Уутат шүүлтүүр №1 хий хураагуур /6м3/	ш	1	DN32	8
5	Уутат шүүлтүүр №2 хий хураагуур /5м3/	ш	1	DN50	8
6	Уутат шүүлтүүр №2 хий хураагуур /6м3/	ш	1	DN32	8
7	Уутат шүүлтүүр №3 хий хураагуур /5м3/	ш	1	DN50	8
8	Уутат шүүлтүүр №3 хий хураагуур /6м3/	ш	1	DN32	8
9	Үнсний бункерийн хий хураагуур /2м3/	ш	1	DN32	8
10	Компрессорын цуглуулах хий хураагуур /20м3/	ш	1	DN65	8
11	Компрессорын сервисийн хий хураагуур /20м3/	ш	1	DN65	8
12	Компрессорын технологийн хий хураагуур /20м3/	ш	1	DN65	8
13	Хими цех технологийн хийн бак /3м3/	ш	1	DN32	8
14	Хими цех цуглуулах хий хураагуур /3м3/	ш	1	DN32	8

ЖАГСААЛТ ГАРГАСАН
ЗУУХАН ЦЕХИЙН ДАРГА

Э.АРИУНБОЛД

ҮНИЙН САНАЛ

ХАРИЛЦАГЧ
ТӨСЛИЙН НЭР
БАЙРШИЛ

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ОГНОО
ЭЭЛЖИТ ҮЗЛЭГ ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА
УЛААНБААТАР ШАЛГАХ ХУГАЦАА

2022-09-12
30 хоног
2 хоног

№	Ажлын нэр	Шалгах аргачлал	Хэмжих нэгж	Эзлэхүүн	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Шохойн чулуу №1 хий хураагуур	Хийн сорил	м3	10	₮ 800,000	₮ 800,000
2	Шохойн чулуу №2 хий хураагуур		м3	10	₮ 800,000	₮ 800,000
3	Утаат шүүлтүүр №1 хий хураагуур		м3	5	₮ 400,000	₮ 400,000
4	Утаат шүүлтүүр №1 хий хураагуур		м3	6	₮ 480,000	₮ 480,000
5	Утаат шүүлтүүр №2 хий хураагуур		м3	5	₮ 400,000	₮ 400,000
6	Утаат шүүлтүүр №2 хий хураагуур		м3	6	₮ 480,000	₮ 480,000
7	Утаат шүүлтүүр №3 хий хураагуур		м3	5	₮ 400,000	₮ 400,000
8	Утаат шүүлтүүр №3 хий хураагуур		м3	6	₮ 480,000	₮ 480,000
9	Үнсний бункерын хий хураагуур		м3	2	₮ 160,000	₮ 160,000
10	Компрессорын цуглуулах хий хураагуур		м3	20	₮ 1,600,000	₮ 1,600,000
11	Компрессорын сервисийн хий хураагуур		м3	20	₮ 1,600,000	₮ 1,600,000
12	Компрессорын технологийн хий хураагуур		м3	20	₮ 1,600,000	₮ 1,600,000
13	Хими цех технологийн хийн бак		м3	3	₮ 240,000	₮ 240,000
14	Хими цех цуглуулах хийн хураагуур		м3	3	₮ 240,000	₮ 240,000

НИЙТ ДҮН /НӨАТ-ГҮЙ/

₮ 9,680,000

НӨАТ - 10%

₮ 968,000

НИЙТ ДҮН

₮ 10,648,000

